

Тандалт судалгааны зөвлөмж

1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагад нэвтрэх үед суралцагч, багш, ажилчдын биеийн байдлын бүртгэл хөтлөх

1. Сургалтын байгууллага нь сургуулийн орчинд коронавируст халдвараас сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах багийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулна.
2. Сургалтын байгууллага нь багш, ажилтан, суралцагч бүрд QR код бүхий үнэмлэхийг системээс хэвлэн олгоно. QR код бүхий үнэмлэхийг менежер, анги удирдсан багш мөн эцэг, эхийн системээс хэвлэх боломжтой.



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: 263727
И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2024.12.23 № 2/6745
танай _____-ны № _____-г

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Майкрософт компаний "Оффис 365 систем"-ийг боловсролын салбарт нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа "Боловсролын мэдээллийн технологийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, аймаг, нийслэлийн Боловсролын газарт админ эрхийг цахим шуудангаар, багшид дээрх системийн АЗ эрх, бусад ажилтан, суралцагч нарт А1 эрхийг үүсгэж боловсролын салбарын мэдээллийн <https://esis.edu.mn/> системээр хүргүүлнэ.

Админ болон хэрэглэгчийн сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн үе шаттай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, аймаг, нийслэлийн Боловсролын газрын холбогдох албан хаагчдад сургалт хийхээр төлөвлөсөн тул сургалтыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж, сургалтад хамрагдсан албан хаагчдын бүртгэл, жагсаалтыг цахим шуудангаар [/info@edu.mn/](mailto:info@edu.mn)-д хүргүүлэн, хамтран ажиллах нь зүйтэй.

Сургалтын хуваарь, системийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор авна уу.



<https://help.esis.edu.mn/content/23338>

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН



14219 8263

3. Сургалтын байгууллагын тандалтын баг нь мобайл төхөөрөмж дээр ESIS аппликэйшнийг татаж суулгасан байна.
4. Тандалтын багийн нэвтрэх бүртгэл хөтлөх системийн хэрэглэгчийн эрхийг Аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтсээр дамжуулан хүргүүлсэн.
5. Багш, ажилтан, суралцагчдыг сургуульд ирэхэд Тандалтын баг халууныг хэмжиж, үнэмлэхийн QR кодыг ESIS аппликэйшн ашиглан бүртгэж нэвтрүүлнэ.
6. Сургалтын байгууллагад нэвтрэх үед багш, ажилтан, суралцагч хэвийн бус халуунтай, ковидын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд тусгаарлаж, эрүүл мэндийн асуумжийг системд бүртгэж бөглөнө.

Хавсралт 1

Оффис 365 системийн сургалтын хуваарь

№	Огноо	Нэр		Цаг	Бүлэг
1	2021.12.23 /Пүрэв/	Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээ хариуцсан бүх ажилтны сургалт	Админы сургалт	10:00-13:00	Админууд
				14:00-17:00	
2	2021.12.24 /Баасан/	Архангай аймаг	Хэрэглэгчийн сургалт /өглөөний/	10:00-13:00	Бүлэг 1
		Баян-Өлгий аймаг			
		Баянхонгор аймаг Булган аймаг	Хэрэглэгчийн сургалт /оройн/	14:00-17:00	Бүлэг 2
3	2021.12.27 /Даваа/	Говь-Алтай аймаг	Хэрэглэгчийн сургалт /өглөөний/	10:00-13:00	Бүлэг 1
		Говь-Сүмбэр аймаг			
		Дархан-Уул аймаг Дорноговь аймаг	Хэрэглэгчийн сургалт /оройн/	14:00-17:00	Бүлэг 2
4	2021.12.28 /Мягмар/	Дорнод аймаг	Хэрэглэгчийн сургалт /өглөөний/	10:00-13:00	Бүлэг 1
		Дундговь аймаг			
		Завхан аймаг Орхон аймаг	Хэрэглэгчийн сургалт /оройн/	14:00-17:00	Бүлэг 2
5	2022.01.03 /Даваа/	Сэлэнгэ аймаг	Хэрэглэгчийн сургалт /өглөөний/	10:00-13:00	Бүлэг 1
		Сүхбаатар аймаг			
		Төв аймаг Увс аймаг	Хэрэглэгчийн сургалт /оройн/	14:00-17:00	Бүлэг 2
6	2022.01.04 /Мягмар/	Ховд аймаг	Хэрэглэгчийн сургалт /өглөөний/	10:00-13:00	Бүлэг 1
		Хэнтий аймаг			
		Хөвсгөл аймаг		14:00-17:00	Бүлэг 2

2. Тандалтын баг болон анги удирдсан багш